

## **Петро Матад Лимитед (“Петро Матад” эсвэл “Компани” гэх)**

### **Хайгуулын үйл ажиллагааны талаарх шинэ мэдээлэл**

Петро Матад (AIM: MATD) нь тус компаний Монгол Улс дахь ХХ дугаар талбай дээрхи өрөмдлөгийн үйл ажиллагаа болон IV ба V талбайнуудад явуулж буй хайгуулын ажиллагааны явцийн талаарх дараахи шинэ мэдээллийг хүргүүлж байна.

#### **XX дугаар талбайн өрөмдлөгийн хөтөлбөр**

2010 оны 7 сарын 14-нд мэдээлсэнчлэн тус компанийн Давсан Толгой-1 (ДТ-1) хайгуулын цооног нь эцсийн гүн болох 1220 метрт хүрсэн болно. Уг цооног нь төлөвлөсөн 1075 метрээс 1146 метрийн хооронд орших Цагаанцавын давхаргыг өнгөрч, хувирмал ул чулуулагтаа хүрсэн байна. Цагаанцавын давхаргын энэхүү 71 метрийн хэсэгт нийтдээ 35 метрийн урттай, тосны шинж тэмдэг бүхий элсэн чулуун болон конгломератын 6 үед газрын тос болон шаврын хийн илрэл агуулагдсан байна.

2010 оны 7 дугаар сарын 14-ний өдрөөс эхлэн каротажийн судлагаа, цооногийн бэхэлгээ болон цементлэх ажлууд хийгдсэн. Уэдерфордын хийсэн каротажийн бичиглэлийн анхны петрофизикийн дүн шинжилгээгээр өмнөх өрөмдлөгийн үр дүнг баталсан болохыг Компани мэдээлж байгаадаа баяртай байна.

Хэдийгээр нэмэлт шинжилгээ хийгдэх шаардлагатай байгаа боловч каротажийн бичиглэлээр дээрхи элсэн чулууны 6 бүсүүд нь нүх сүвшилт (дунджаар 25%) болон нэвчүүлэмж сайтай бөгөөд нийтдээ 12 метрийн зузаантай нефтлэг үе байгааг харуулж байна. ДТ-1 цооногийн давхаргын чанарыг бага нягтрал болон Тамсагийн сав газрын хэмжээн дэх хамгийн өндөрт өргөгдсөн атирааг үүсгэж буй Давсан Толгойн гүдэн бүтцийн оройн хэсгийн дагуух эртнээс хуримтлагдсан болон одоо хуримтлагдаж буй нүүрсустөрөгчийн агууламжтай холбож үзэж болно.

Дээжийг газрын тосны давхарга болон шинж чанарыг тодорхойлуулахаар АНУ дахь лабораторуудад илгээсэн. Петрофизикийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үр дүнг хөтөлбөрийн дараагийн цооногийн туршилтын загварыг гаргахад ашиглах болно. Компани нь дээрхи туршилтанд ашиглах цооногийн засварын цамхагуудыг судалж байгаа бөгөөд гурван цооногийн өрөмдлөгийн хөтөлбөр дууссаны дараа энэ жилд аль цооногт туршилт явуулах талаархи шийдвэрийг гаргах болно.

Өрмийн машиныг Компанийн хоёрдахь цооног болох ДТ-2 руу ойрын хугацаанд нүүлгэх бөгөөд өрөмдлөгийн ажиллагаа эхлэх үед цаашдын мэдээллийг хүргэх болно.

#### **IV ба V дугаар талбайнуудын хайгуулын ажил**

Монгол Улсын төв хэсэгт орших тус компанийн IV ба V дугаар талбайнуудад анхны 2D чичирхийллийн судалгааг эхлүүлээд байгаа билээ. Монголын геофизикийн судлагааны Хэт ХХК нь Петро Матадын удирдлага, хяналтын дор чичирхийллийн 7 шугамыг хамарсан 360 км судлагааны ажлыг гүйцэтгэж байна.

Түүнчлэн Монголын геофизикийн зөвлөх компани болох Геосан ХХК нь дээрхи хоёр талбайн хэмжээнд хүндийн хүчний гүйцээх судалгааг явуулж байгаа болно. 4500 цэгийг

багтаасан өмнөх судлагааг орчин үеийн хүндийн хүчний судлагааны мэдээлэл дээр нэмж, Талбайнуудын нийт 73,498 хавтгай дөрвөлжин км талбайд торлолыг 2км х 2км-н хэмжээтэй болгох юм. Одоогийн хүндийн хүчний судлагааны мэдээлэл нь чичирхийллийн судлагаанд голлон анхаарч байгаа таван дэд сав газруудын хил хязгаарыг тодорхойлж байгаа ажээ.

2011 онд хийхээр анх төлөвлөж байсан чичирхийллийн хээрийн ажлыг 2010 онд хийсэн нь Компани Монгол Улсын төв хэсгийн сав газруудын талаархи геологийн мэдлэгээ түргэн хугацаанд сайжруулж чадсаны үр дүн юм. Компанийн хайгуулын баг саяхан олон улсын болон Монголын мэргэжилтнүүдийн тусламжтайгаар геологийн хээрийн судалгаануудыг хийж гүйцэтгэж, талбайдын хэмжээнд хэтийн төлөв бүхий бүтцүүдийг тодорхойлон дунд төрмөлийн үеийн нүүрсустөрөгчийн системүүдийн үндсэн элементүүдийг баталгаажуулсан юм. Эдгээр ололтууд нь хайгуулын хөтөлбөрийг илүү хялбар дөт болгож төлөвлөж байснаас хавьгүй богино хугацаанд өрөмдлөгө хийх газруудыг тодорхойлох зорилт бүхий ажил юм. Эдгээр ололтууд нь өрөмдлөг хийх газруудыг анх тооцоолж байснаас илүү богино хугацаанд тодорхойлох хайгуулын хөтөлбөрийг оновчтой болгосон юм.

Монгол Улсын Газрын Тосны Газар саяхан Компанийн хайгуулын шинэчлэгдсэн хөтөлбөр, төсвийг баталсан. Дээрхи шинэчлэлтүүд болон нэмэлт ажлуудын дүнд хоёр талбайд явуулах хайгуулын ажлын зардлыг 18%-иар нэмэгдүүлсэн.

“Тамсагийн сав газрын хойд хэсгийн гүнд байрлах Тосон Уулын дагуух Давсан Толгойн давхаргын чанар сайн байгааг ДТ-1 цооногийн каротажийн судалгаагаар баталлаа.

Цаашилбал Давсан Толгойн бүтэц нь сав газрынхаа хувьд региональ хураагуур гэж үзэж буй бидний анхны загварыг баталж буй өөр нэгэн алхам юм.

Бид цооногийн анхны үр дүнгүүдэд маш их сэтгэл хангалуун байгаа бөгөөд лабораторын шинжилгээнүүдийг дуусахыг бид хүлээж байна. Бид өөрсдийн мэдлэгийг нэмэгдүүлж, Давсан Толгойн үндсэн гүдэн бүтцийн боломжит гарцыг баталгаажуулах зорилгоор 2010 онд хийгдэх үлдсэн хоёр цооногийн өрөмдлөгийн хөтөлбөрийг боловсруулна. Түүнчлэн бид IV болон V дугаар талбайн урт хугацааны хэтийн төлвийн талаар маш өөдрөг үзэлтэй байгаа” гэж Компанийн Ерөнхий Гүйцэтгэх Захирал Даглас МакГэй мэдэгдлээ.

Энэхүү мэдээний техникийн мэдээллийг тус Компаний Хайгуулын Менежер доктор Жэймс Күүган хянаж үзсэн болно. Доктор Күүган Хойд Америк болон олон улсын хайгуул, боловсруулалтын ажлын 29 жилийн туршлагатай газрын тосны геологич хүн. Тэрээр Америкийн Газрын Тосны Геологичдын Холбоо болон Америкийн Геологийн Нийгэмлэгийн гишүүн.

#### **Редакторуудад зориулсан тайлбар:**

##### **Петро Матадын тухай**

Петро Матад нь газрын тосны хайгуул болон цаашдын олборлолт, үйлдвэрлэлийг Монгол Улсад эрхлэх чиглэлээр ажиллаж байгаа группын толгой компани юм. Тус групп нь Монгол улсын засгийн газартай байгуулсан гурван Бүтээгдхүүн Хуваах Гэрээг (БХГ) дангаараа эзэмшигч байгууллага болно. Үндсэн хөрөнгө нь XX дугаар талбай дээр байгуулсан БХГ бөгөөд уг талбай нь Монголын зүүн хэсэгт орших 14,250 км<sup>2</sup> газрын тосны талбай юм. Нөгөө хоёр IV, V дугаар талбайнууд нь Монголын нутгийн төв хэсэгт орших ба талбайн нийлбэр хэмжээ нь 73,498 км<sup>2</sup> болно.

Петро Матад нь Айле эф Ман (Isle of Man)- нд бүртгэлтэй бөгөөд 1483V дугаартай компани юм. Бүртгэгдсэн оффисын хаяг нь Виктори Хаус, Проспект Хилл, Даглас, Айле эф Ман, Ай ЭМ1 1ИКью болно.

Цаашдын мэдээллийг хүмүүстэй холбоо барьж авна уу:

Петроматад Лимитед Дуглас Ж. МакГей – Ерөнхий Гүйцэтгэх Захирал	+976-11-331099
Вестхаус Секюритиз Лимитэд Ричард Бати\Петре Нортон	+44/0/ 20 7601 6100
Банксайд Консалтантс Симон Ротсчайлд\Оливер Уинтерс\Люиси Масон	+44/0/ 20 7367 8888